



Ж.САМБУУГИЙН НЭРЭМЖИТ
МАЛ АЖ АХУЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХҮРЭЭЛЭН



ШУТСан
УЛСЫН ХӨГЖИЛ ШИНЖЛЭХ УЛААМААС ЭХТЭЙ

ЦАРГАСНЫ ХОРГОЛЖИН ТЭЖЭЭЛИЙГ НЭМЭГДЭЛ ТЭЖЭЭЛЭЭР АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ



**“БУУРЦАГТ УРГАМЛААР УУРАГТ ТЭЖЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭХ”
ИННОВАЦИЙН ТӨСӨЛ (2017-2019 он)**

Зөвлөх: Доктор Д. Алимаа

Гүйцэтгэгчид: Доктор Г.Удвал

Т.Баттогтох

П.Сүхбаатар

Ч.Уранхайч

Д.Пүрэвдолгор

Д.Сангажав

Ж.Гантуяа

Царгасны хорголжин тэжээлээр Эрчимжсэн аж ахуйн саалийн үнээг тэжээх

Саалийн үнээ маллаж байгаагийн гол зорилго нь аль болох хямд зардлаар чанартай арвин сүү үйлдвэрлэж зах зээлд борлуулан ашиг орлогоо нэмэгдүүлэх явдал юм. Саалийн үнээнд ямар тэжээлийг хэрхэн яаж өгч тэжээллэгийн ямар горимын дагуу хир зэрэг тэжээлээр тэжээх хэрхэн тэжээсэн нь сүүний гарц, түүний чанарт шууд хамаардаг. Малчин бол мал хэмээх амьтны жинхэнэ технологч нь юм. Саалийн үнээ нь сүү, үр төл өгөхөд олон олон төрлийн эрдэс, биологийн идэвхт болон шимт бодисууд чухал шаардлагатай.

Өвөл, хаврын улиралд царгасны хорголжин тэжээлийг Алатау үүлдрийн эрчимжсэн аж ахуйн сүүний үнээнд хоногт 3 кг хоногт нэмэгдэл тэжээлээр өгсөнөөр сүүний гарц 2.1л нэмэгдэж сүүний тослог 0.4 % -аар нэмэгдэх боломжтой байна.

Иймд сүүний эрчимжсэн аж ахуйд уургийн дутагдалыг нөхөхөд царгасны хорголжин тэжээлээр тэжээх хэрэгтэй байна.

Царгасны хорголжин тэжээлээр бэлчээрийн өсвөр үхэр тэжээх

Монгол мал байгаль цаг уурын эрс тэс нөхцөлд бэлчээрээр маллахад нэн сайн зохицсон, тэсвэр хатуужил сайтай боловч сүүлийн жилүүдэд малын тоо толгой нэмэгдэж бэлчээр даац хэтэрснээс манай орны мал сүрэг өвөл, хаврын улиралд намар авсан амьдын жингийнхээ 25-30 хувийг алдаж турж, ядарч, доройтон онд ордог болсон. Иймээс өсвөр үхрийг өвөл, хаврын улиралд өглөө бэлчээрт гарах болон орой бэлчээрээс ирэх үед уураг амин дэмээр баялаг царгасны хорголжин тэжээлийг 280-300 кг амьдын жинтэй өсвөр үхэрт хоногт 2.6 кг-аар тооцон нэмэгдэлээр өгснөөр хоногийн нэмэгдэл жин 200 г-аар нэмж байна.

Нэмэгдэл тэжээлийн хэрэгцээ нь бүс нутгийн онцлог, байгаль цаг уурын байдал бэлчээрийн ургац, малын нас, хүйс, төрөл, ашиг шимийн чиглэл, тарга хүч зэргээс хамаарч харилцан адилгүй байна. Говийн бүсэд 60, хээрт 90, ойт хээрт 120 хоног нэмэгдэл тэжээлээр тэжээх шаардлагатай байдаг. Нэмэгдэл тэжээлийг үйлдвэрлэхдээ тухайн бүс бүслүүрийн онцлогт тохирсон нэмэгдэл тэжээлээр тэжээх хоногыг тооцож үйлдвэрлэхийг анхаарах нь зүйтэй юм. Царгасны хорголжин тэжээлийг бог малд нэмэгдэл тэжээл болгон хоногт 150-200 гр өгч болно.

Усалгааг тухайн жил унаж байгаа хур тунадаснаас хамааран 4-5 удаа 400-450 м³/га нормоор услана. Царгасыг 6-р сарын 20-оор тарина.

Царгасны амьдралын эхний жил ургац авахгүй харин хоёр дахь жилээс хавар эрт услаж 7-р сарын 15-20 –ны хооронд анхны хадалт хийх боломжтой юм. Царгас цэцэглэлтийн үедээ шимт чанараар хамгийн өндөр байдаг. Усалгааг зохих шаардлагын дагуу бүрэн хийж чадсан үед 1 га- аас 5-6 тн ногоон өвс хураан авна. Дараагийн хадалтыг 8-р сарын сүүлч 9-р сарын эхээр хадаж 1 га талдбайгаас 3-4 тн ногоон өвс хураан авах боломжтой.

Царгас хадах

Ахиу ургац авах, тариалангийн газрыг зөв ашиглах, ургамлын нөхөн ургах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор зохистой өндөрт нь хадах учиртай. Ургамлыг хадахдаа дэл, далан үлдээхгүйгээр хадвал зохино. Царгасыг цэцэглэлтийн үе шатанд Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж болон бага хэмжээний талбайд гар хадуур ашиглан хөрснөөс 5-8 см өндөртэй хадна. Хадуурын ир хурц, хадах хурд жигд байх хэрэгтэй.

Царгасыг хатаах

Царгасыг хадах үед 60-70 хувийн чийгтэй байдаг ба унасан өтгөн массыг талбайд удаан байлгахад, хур бороотой үед амархан харлаж муудан, өвсний шимт чанарыг бууруулдаг. Иймд өнжөөд тармах доод хэсгийг нь дээр нь гаргах замаар жигд сайн эргүүлж сэврээж хатаах шаардлагатай. Эсвэл зориулалтын өвс хатаах саравчинд цэцэг, навчтай нь жигд хатаана. Хатаалтыг 15-16 хувийн чийгтэй болтол хатаавал зохилтой.

Царгасыг хэрчиж жижиглэх

Хатаасан царгасыг навч, цэцэгийг хаягдалгүйгээр 2-3 см урттай хэрчиж жижиглэнэ.

Царгасыг хорголжлох

Бутлагч машинаар тэжээлийн түүхий эдийг нунтаглаж, царгасны хорголжин тэжээлд үндсэн түүхий эдээр царгас барьцалдуулагчаар улаанбуудай эрдсийн нэмэгдэл давс (хужир, шүү) 100кг хорголжин тэжээл бэлтгэхэд улаанбуудай 5%-д буюу 5кг эрдэс 2% буюу 2кг царгас 93 хувьд тооцон хорголжин тэжээл бэлтгэв.

Царгасны хорголжин тэжээлийг ийнхүү бэлтгэн үйлдвэрлэхэд 8,62 МДж солилцлын энергитэй 18,6 % нийт уураг, 2,5 % нийт тослог, 9,3 % нийт эслэг, 5,2 % нийт үнстэй юм.

Царгасны хорголжин тэжээлийн Эрчимжсэн аж ахуйд болон бэлчээрийн мал малалгаатай өсвөр үхэрт нэмэгдэл тэжээлээр ашиглах нь зохимжтой гэж үзэж байна.

ЦАРГАСНЫ ХОРГОЛЖИН ТЭЖЭЭЛД БЭЛТГЭХ ҮЕ ШАТ



6-р сарын 15-нд тарьсан
“Бургалтай” сортын Царгас



Эхний жилдээ 20-35 см өндөр
ургаж, өвөлжилтөнд шилжсэн.



Царгасыг тэжээлд бэлтгэж
хатааж буй байдал.

ХАТААСНЫ ДАРААХ НУНТАГЛАСАН ЦАРГАС



2019.11.06

Тэжээл бэлтгэх бага оврын тоног, төхөөрөмж

Буурцагт ургамлаар тэжээл хэрчигч, тэжээл бутлагч, тэжээл тэжээл холигч, хорголжлогч бүхий бага оврын тоног төхөөрөмжүүдийг ашиглаж болно.

Хорголжин тэжээл үйлдвэрлэх схем



ЦАРГАСНЫ ХОРГОЛЖИН ТЭЖЭЭЛИЙГ НЭМЭГДЭЛ ТЭЖЭЭЛЭЭР АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ

Бэлчээрийн монгол мал жилийн 2/3 буюу 240 хоногийн турш дан ганц хагд бүхий бэлчээрт идээшилдэг. Өвөл, хаврын улиралд бэлчээрийн ургамлын шимт чанар зуныхаас 2-3 дахин, шингэх протеин 3-4 дахин буурч, хүйтний улиралд мал хоногт шаардлагатай тэжээлийнхээ 40-50%, шингэх протеины 30-35%-ийг бэлчээрээс авдаг байна.

Малын биед уураг, эрдэс дутагдсанаар өсөлт хөгжилт саарч, өвчин эмгэгт нэрвэгдэх нь нэмэгдэн, амьдын жин болон ашиг шим нь буурдаг. Дан ганц бэлчээрийн мал биш эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа тохиолдолд нэг малаас авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх мөн өвлийн улиралд малыг эцээж тураахгүй байх үүднээс нэмэгдэл тэжээлээр тэжээдэг.

Төрөл бүрийн малын ашиг шимийг өндөр байлгах зорилгоор уургийн агууламж ихтэй тэжээлээр бие махбодын хэвийн үйл ажиллагааг зайлшгүй хангах шаардлагатай байдаг. Энэ нь малын үүлдэр, ашиг шимийн чиглэл, нас, хүйс, амьдын жин зэргээс хамаарч харилцан адилгүй байдаг.

Малын бие махбодын уургийн дутагдалыг нөхөхийн тулд уургийн агууламж өндөр тэжээл буюу царгас, тэжээлийн буурцагт ургамлаар төрөл бүрийн тэжээл бэлтгэх хэрэгтэй юм.

Олон наст буурцагт ургамлаас Монгол орны эрс тэс нөхцөлд дасан зохицсон, ургах найдвартай арвин ургац өгч байгаа “Бургалтай” сортын царгас нь малын тэжээлийн үнэт таримал ургамал юм. Царгас нь тэжээлийн төдийгүй агротехникийн чухал ач холбогдолтой. Ойт хээрийн усалгаатай нөхцөлд 50-60 ц/га, усалгаагүй нөхцөлд 35-40 ц/га өвсний ургац өгдөг юм.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнд “Буурцагт ургамлаар уурагт тэжээл үйлдвэрлэх” инновацийн төслийг 2017-2019 ондуудад хэрэгжүүлж бэлчээрийн мал аж ахуй болон хагс эрчимжсэн аж ахуйд тэжээлийн туршилт хийсэн. Өрхийн хэмжээнд ашиглаж болохуйц бага оврын хэрчигч, нунтаглагч, холигч, хорголжлогч тэжээлийн машиныг ашиглан царгасны хорголжин тэжээл үйлдвэрлэв. Үйлдвэрлэсэн тэжээлийг Төв аймгийн Батсүмбэр сумын сүүний фермерт Алатау үүлдрийн үхэрт, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын бэлчээрийн маллагаатай монгол өсвөр үхэрт уургийн дутагдлыг нөхөх зорилгоор нэмэгдэл тэжээлийн туршлага, судалгаа явуулж, түүний үр дүнд тулгуурлан дараах зөвлөмжийг боловсруулав.

Царгасыг тэжээлд тариалах агротехник

Атаршсан газар болон тариалангийн аль ч талбайд тариалсан хөрс боловсруулалт, тариалах хугацаа, үр суулгах гүн тариалахтай адилхан. Царгасыг тэжээлд зориулан Монгол орны аль ч бүсэд тарихдаа 1 га талбайд 12 кг/га нормоор, энгийн мөрөөр, мөр хооронд 15-20 см зайтай үрлэнэ. Тариалсны дараа заавал усан булаар булдах хэрэгтэй.

Ашигласан хэвлэл

- 1.Баатар Д (1980) Малын биологийн зарим асуудал
- 2.Жавзансүрэн Д (1914) Царгас уургийн хямд эх үүсвэр мөн онол практикийн бага хурал илтгэлийн хураангуй
- 3.Жигжидсүрэн С (2011) Тэжээлийн ургамал тариалах агро зөвлөмж
- 4.Жигжидсүрэн С (2016) Тэжээлийн ургамал тариалах зөвлөмж
- 5.Жигжидсүрэн С (2005) Бэлчээрийн менежмент
- 6.Мяхдадаг Б (1990) Чанартай тэжээл арвин ашиг шим
- 7.Цэдэн Д (1967) Багсармал холимог тэжээл үйлдвэрлэн ашиглах тухай
- 8.Цэрэндаш С (2011) Бэлчээр зохистой ашиглах арга
- 9.Цэрэндулам Р (2011) Монгол орны малын тэжээл

Хаяг: УБ, ХУД, 11-р хороо, Зайсан,
Мал Аж Ахуйн Эрдэм Шинжилгээний Хүрээлэн

Утас: 976-11-341936
976-99081940

И-мэйл: udangaus@gmail.com